**"Мандал Даатгал" ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан**

| | |
|---|---|
| **Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/** | |
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | |
| | |
| *Тайлагнах хугацаа* | *2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр* |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | *Мандал Даатгал ХК, 000172636, MSE: MNDL, 7575-2000* |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | *Монголын хөрөнгийн бирж* |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | *Ердийн даатгалын салбар* |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | *Нексиа глобал монголиа аудит ХХК, 2023.05.12* |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | *624,301,600* |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | *Дата аналист Х.Номин-Эрдэнэ,*<br>*Гүйцэтгэх захирал Ж.Батчимэг* |
| | |

| | | |
|---|---|---|
| 1 | *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* | |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт* | *Тайланг хавсаргав* |
| | *Орлогын тайлан* | *Тайланг хавсаргав* |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | *Тайланг хавсаргав* |
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | *Тайланг хавсаргав* |
| 1.1 | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* | |
| | *Аудитын дүгнэлт хавсаргав.* | |
| 1.2 | *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/* | |
| | *Аудитын дүгнэлт хавсаргав.* | |
| 2 | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* | |
| 2.1. | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | *Нийт хөрөнгийн өгөөж (ROA): 6%*<br>*Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): 18%* |
| 2.2 | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | *Төлбөрийн чадварын харьцаа: 157%* |
| 2.3 | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* | *2023 оны байдлаар нийт хөрөнгө, нийт хураамжийн орлого, хөрөнгө оруулалтын орлого, цэвэр ашгийн үзүүлэлтээр салбартаа тэргүүлж нийт хураамжийн орлогын хэмжээгээр зах зээлд 28% эзэлж байна.*<br>*Тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүнүүд дээр өөрчлөлт орсон*<br>*o Simple*<br>*o Simple Plus*<br>*o Стандарт*<br>*o Стандарт плас*<br>*o Цахилгаан ТХД (Үндсэн)*<br>*o Цахилгаан ТХД (Нэмэлт)* |
| 2.4 | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/* | *Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй* |
| 2.5 | *Тайлант хугацаанд авсан зээлийн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл* | *2023 онд Засгийн газар, ББСБ, банкнаас ямар нэг авсан зээл байхгүй* |
| 3 | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |
| | *Монгол улсын "Компаний тухай" хуулийн 84.4.4-т заасан "Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх" үүргийг биелүүлж сонирхлын зөрчлөөс зайлсхийж ажилласан.* | |
| 4 | *Цалин урамшууллын мэдээлэл* | |
| | *Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат, хараат бус гишүүдэд 2023 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан төсвийн дагуу цалин урамшуулал олгосон.* | |
| 5 | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* | |
| | *Компанийн бүтэц, зохион байгуулалт 2023 оны 4 дугаар сарын 14-ний өдөр Гүйцэтгэх захирлын 23/127 тоот тушаалын дагуу шинэчлэгдэн батлагдсан.*<br>*Борлуулалт суурьтай бүтцийг нэвтрүүлж, ажилтнуудыг илүү мэргэшсэн түвшинд өргөн цар хүрээтэйгээр ажиллах боломжийг бүрдүүлсэн.*<br>*ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирал:*<br>*o ТУЗ-ийн ердийн гишүүн: Ө.Ганзориг, Т.Батзул, Ш.Гантуяа, О.Ганжолоо, Л.Ганзоригт, Г.Дашдэндэв*<br>*o ТУЗ-ийн хараат бус гишүүн: Жеймс Бернард Двайер, Ж.Дэлгэрсайхан, Г.Гантулга*<br>*o Гүйцэтгэх захирал : Ж.Батчимэг* | |
| 6 | *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл* | |
| | *Байхгүй* | |
| 7 | *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/* | |
| | *Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрчлөлт ороогүй.*<br>*2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх нөлөө бүхий хувьцаа эзэмшигч*<br>*1 . Голомт Файнэншил Групп ХХК - 255,027,204 - 40.85%*<br>*2. Юу Эм Си Капитал ХХК - 233,988,240 - 37.48%*<br>*3. Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК - 45,386,726 - 7.27%*<br>*4. Олон нийт - 89,899,430 - 14.40%* | |
| 8 | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* | |
| | *2023 онд татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй* | |
| 9 | *Ногдол ашгийн мэдээлэл* | |

<table>
<tr><td></td><td colspan="2">2023 онд ногдол ашиг олгоогүй.</td></tr>
<tr><td>10</td><td colspan="2">Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</td></tr>
<tr><td></td><td colspan="2">• Улсын Гуравдугаар Төв Эмнэлэгтэй хамтран “50 хүний амь аврах төсөл-АЛТЕПЛАЗА” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн бөгөөд төслийн хүрээнд 2 ажлын амжилттай хийж гүйцэтгэсэн.<br>Мандал Даатгал ХК-ийн зүгээс 50 тунг захиалан Улсын Гуравдугаар Эмнэлэгт хүлээлгэн өгсөн бөгөөд 35 хүний амь насыг авраад байгаа юм.<br>• Мандал Эрсдэлийн Сургууль<br>2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн уг төсөл нь 4-12 насны хүүхдүүдэд эрсдэлийн боловсрол олгоход чиглэсэн бөгөөд өдгөө 25,000 гаруй хүүхэд багачуудыг онлайн хичээлдээ хамруулаад байна. Монгол Улсад жил бүр 40,000 хүүхэд урьдчилан сэргийлэх боломжтой шалтгааны улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирдог харамсалтай тоон мэдээлэл байдаг. Уг эрсдэлийг бид бууруулахын тулд өөрсдийн хувь нэмрийг оруулж 4-12 насны хүүхдүүдийн дунд түгээмэл тохиолдох эрсдэлүүдийн талаарх 2 бүлэг 18 видео хичээлийг тэдний хөгжлийн онцлогт суурилан бэлтгээд байна.<br>• Эрсдэлийн Форум<br>2023 онд “Эрсдэлийн Форум” 14 дэх удаагийн арга хэмжээг Шадар Сайдын ажлын алба, Стандарт Хэмжил Зүйн Газар, Онцгой Байдлын Ерөнхий газруудтай хамтран Нийслэл болон 21 аймгийн хүрээнд 3 хоногийн турш амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээ нь улс оронд тулгарч болзошгүй нийгэм, эдийн засаг, гамшгийн эрсдэлүүд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга замын талаар хэлэлцэж бодит шийдлийг эрэлхийлж, төр, хувийн хэвшил, иргэний зүгээс эрсдэлийг удирдахад хувь нэмэр оруулсаар ирсэн билээ.</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:</td></tr>
<tr><td></td><td>Овог, нэр: Ж.Батчимэг<br><br>Албан тушаал: Гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: ……………………………………<br><br>(Тамга/тэмдэг)</td><td>Овог, нэр: Э.Булган<br>Албан тушаал: Нексиа глобал монголиа аудит ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: ……………………………………<br><br>(Тамга/тэмдэг)</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Овог, нэр: Х.Номин-Эрдэнэ<br><br>Албан тушаал: MIS, дата анализын хэлтсийн дата аналист<br><br>Гарын үсэг: ……………………………………</td></tr>
</table>

A member of Nexia International

**НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК**
Юу Би Тавэр Плас барилга, 609 тоот
Баянгүрх дүүрэг, 25 дугаар хороо
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: +976 7740 4848
Веб хаяг: www.nexia.com

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

---

## Аудиторын дүгнэлт

Бид Мандал Даатгал ХК (цаашид "Компани" гэх)–ийн 2023 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

## Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

## Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлттэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)–ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

### Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"–ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно

**НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид:

| | |
|---|---|
| **Э.БУЛГАН** | **У.НАРАНДЭЛГЭР** |
| Партнер | Аудитор |

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2024 оны 2 дугаар сарын 23

## ТОВЧИЛСОН ҮГС

Санхүүгийн тайланд товчилсон үгсийн дараах хэв маягийг ашигласан болно:

| | |
|---|---|
| НББОУСЗ | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл |
| СТОУС | Санхүүгийн тайлагналийн олон улсын стандартууд |
| АОУС | Аудитын олон улсын стандартууд |
| МОҮН | Мөнгөн орлого үүсгэгч нэгж |
| ГНА | Гэрээний нийт ашиг |
| ХБЭА | Хүлээгдэж буй эрсдлийн алдагдал |
| НХНА | Нэгж хувьцааны ашиг |
| БҮЦӨБДОБ | Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх |
| БҮЦӨАА | Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх |
| Тод | Санхүүгийн тайлангын тодруулгууд |
| БДО | Бусад дэлгэрэнгүй орлого |
| ХХА | Хураамжийн хуваарилалтын арга |
| УХӨТ | Учирсан хохиролын өр төлбөр |
| ҮХХӨТ | Үлдсэн хугацаанд хамаарах өр төлбөр |
| АҮМ | Алдагдал үүсэх магадлал |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

# МАНДАЛ ДААТГАЛ ХК

## 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

| (Мянган төгрөгөөр) | Тод | 2023.12.31 | (Дахин тайлагнасан*) 2022.12.31 |
|---|---|---|---|
| ХӨРӨНГӨ | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 12 | 14,172,386 | 1,037,665 |
| Санхүүгийн хөрөнгө | 13 | 36,389,403 | 39,119,369 |
| Хорогдуулсан өртгөөр бүртгэх | | 28,804,237 | 32,874,921 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх | | 2,989,600 | 1,542,919 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх | | 4,595,566 | 4,701,529 |
| Даатгалын гэрээний хөрөнгө | 9 | 4,733,085 | 4,251,695 |
| Давхар даатгалын гэрээний хөрөнгө | 14 | 1,196,720 | 5,786,124 |
| Авлага | 15 | 690,685 | 110,323 |
| Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо ба бусад хөрөнгө | 16 | 406,864 | 797,548 |
| Бараа материал | 17 | 41,772 | 112,898 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 11.3 | - | 79,750 |
| Үндсэн хөрөнгө | 18 | 1,154,995 | 1,538,997 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 19.1 | 1,005,304 | 939,176 |
| Биет бус хөрөнгө | 20 | 173,445 | 164,174 |
| Борлуулалтын зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө | | 600,438 | 319,000 |
| Нийт хөрөнгө | | 60,565,097 | 54,256,719 |
| ӨР ТӨЛБӨР | | | |
| Даатгалын гэрээний өр төлбөр | 9, 23 | 20,531,548 | 15,412,026 |
| Давхар даатгалын гэрээний өр төлбөр | 14 | 1,368,849 | 6,077,740 |
| Дансны ба бусад өр төлбөр | 21 | 1,107,198 | 1,311,507 |
| Орлогын албан татварын өр төлбөр | 11.4 | 557,734 | 475,722 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 11.3 | 156,041 | - |
| Түрээсийн өр төлбөр | 19.2 | 941,439 | 930,389 |
| Нийт өр төлбөр | | 24,662,809 | 24,207,384 |
| ЭЗДИЙН ӨМЧ | | | |
| Хувьцаат капитал | 22 | 6,243,016 | 6,243,016 |
| Нэмж төлөгдсөн капитал | | 4,441,896 | 4,441,896 |
| Тусгай нөөц сан | | 1,256,290 | 1,256,290 |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан | 7 | 81,022 | 318,137 |
| Хуримтлагдсан ашиг | | 23,880,064 | 17,789,996 |
| Нийт эздийн өмч | | 35,902,288 | 30,049,335 |
| Нийт эздийн өмч ба өр төлбөр | | 60,565,097 | 54,256,719 |

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

* Аудитлагдсан санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 17-ийн дагуу толилуулагдсан ба зарим нэг дүнгийн ангилалыг сольсон ба залруулгууд хийгдсэн тул Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлантай таарахгүй болно (Тодруулга 25).

МАНДАЛ ДААТГАЛ ХК

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

| (Мянган төгрөгөөр) | Тод | 2023 | (Дахин тайлагнасан*) 2022 |
|---|---|---|---|
| Даатгалын орлого | 6, 9 | 24,592,395 | 21,211,492 |
| Даатгалын үйлчилгээний зардал | 6, 9 | (18,280,237) | (13,053,794) |
| Даатгалын үйлчилгээний үр дүн | | 6,312,158 | 8,157,698 |
| Давхар даатгалын хураамжийн төлөлт | | 370,942 | (149,034) |
| Давхар даатгалаас хүлээн авсан нөхөн төлбөр | | 2,997,402 | 1,230,144 |
| Давхар даатгалын цэвэр үр дүн | | 3,368,344 | 1,081,110 |
| Даатгалын үйлчилгээний цэвэр үр дүн | 6 | 9,680,502 | 9,238,808 |
| Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн хүүний орлого | 7 | 5,790,980 | 4,514,956 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгө оруулалтын цэвэр олз | 7 | 1,236,837 | 125,209 |
| Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз | 7 | 149,388 | 499,240 |
| Санхүүгийн хөрөнгө, гэрээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтын өөлчлөлтөөс үүссэн олз, гарз (үнэ цэнийн бууралтын буцаалтыг оруулсан) | 7 | 4,137 | (5,487) |
| Цэвэр хөрөнгө оруулалтын орлого | 7, 13 | 7,181,342 | 5,133,918 |
| Бусад олз / (гарз) | 8 | 665,763 | 119,312 |
| Бусад үйл ажиллагааны зардал | 10 | (10,608,594) | (10,265,436) |
| Бусад санхүүгийн зардал | | (120,670) | (55,972) |
| Татварын өмнөх ашиг | | 6,798,343 | 4,170,630 |
| Орлогын албан татварын зардал | 11 | (708,275) | (394,280) |
| Тайлант жилийн цэвэр ашиг | | 6,090,068 | 3,776,350 |
| Бусад дэлгэрэнгүй орлого / (алдагдал) | 13 | (237,115) | (869,154) |
| Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | | 5,852,953 | 2,907,196 |

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

* Аудитлагдсан санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 17-ийн дагуу толилуулагдсан ба зарим нэг дүнгийн ангилалыг сольсон ба залруулгууд хийгдсэн тул Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлантай таарахгүй болно (Тодруулга 25).

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК ХУУДАС

# МАНДАЛ ДААТГАЛ ХК

## 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| (Мянган төгрөгөөр) | Хувьцаат капитал (Тод 22) | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан | Тусгай нөөц сан* | Хуримтлагд-сан ашиг** | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 2022 оны 1 сарын 1-ээрх | 6,243,016 | 4,441,896 | 1,187,291 | - | 14,013,646 | 25,885,849 |
| Нийт дэлгэрэнгүй орлого | - | - | (869,154) | - | 3,776,350 | 2,907,196 |
| Дахин ангилсан* (Тодруулга 25) | - | - | - | 1,256,290 | - | 1,256,290 |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - |
| 2022 оны 12 сарын 31-ээрх | 6,243,016 | 4,441,896 | 318,137 | 1,256,290 | 17,789,996 | 30,049,335 |
| Нийт дэлгэрэнгүй орлого | - | - | (237,115) | - | 6,090,068 | 5,852,953 |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - |
| 2023 оны 12 сарын 31-ээрх | 6,243,016 | 4,441,896 | 81,022 | 1,256,290 | 23,880,064 | 35,902,288 |

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

* Тусгай нөөц санг Санхүүгийн Зохицуулах Хорооны ("СЗХ") шаардлагад нийцүүлэн байгуулсан бөгөөд СЗХ-той зөвшилцсөний үндсэн дээр Компанийн хувьцаа эзэмшигчид олгох боломжтой (Тодруулга 25).

** Аудитлагдсан санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 17-ийн дагуу толилуулагдсан ба зарим нэг дүнгийн ангилалыг сольсон ба залруулгууд хийгдсэн тул Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлантай таарахгүй болно (Тодруулга 25).

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК ХУУДАС

# МАНДАЛ ДААТГАЛ ХК

## 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| (Мянган төгрөгөөр) | Тод | 2023 | (Дахин тайлагнасан*) 2022 |
|---|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| Татварын өмнөх ашиг | | 6,798,343 | 4,170,630 |
| *Татварын өмнөх ашгийг цэвэр мөнгөн гүйгээтэй тохируулах мөнгөн бус тохируулгаад:* | | | |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 10 | 506,120 | 428,000 |
| Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл | 10 | 327,336 | 413,999 |
| Биет бус хөрөнгийн хорогдол | 10 | 74,329 | 97,799 |
| Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн хүүний орлого | | (5,790,980) | (4,514,956) |
| Өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгө оруулалтын олз | | (1,136,428) | - |
| Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз | | (149,388) | (499,240) |
| Хүүний зардал | | 120,671 | 55,973 |
| Төлсөн хүү | | (120,671) | (55,973) |
| Үндсэн хөрөнгө борлуулснаас олсон (олз) / гарз | 8 | (105,768) | (60,867) |
| Ханшийн бодит бус (олз) / гарз | 8 | 106,428 | 408,881 |
| Ногдол ашиг | | (100,410) | (125,209) |
| Ажлын капиталын өөрчлөлт | | 529,582 | 319,037 |
| Авлагын бууралт/(өсөлт) | | 3,960,947 | (1,126,254) |
| Бараа материалын бууралт / (өсөлт) | | 71,126 | 29,895 |
| Урьдчилж төлсөн төлбөр, тооцооны өсөлт | | (209,754) | (392,647) |
| Хойшлогдсон даатгалын орлогын шимтгэлийн зардлын өсөлт / (бууралт) | | (429,158) | (459,885) |
| Давхар даатгагчид ногдох даатгалын нөөц (өсөлт) / бууралт | | (17,120,949) | (10,397,640) |
| Даатгалын нөөц сангийн (өсөлт) / бууралт | | 22,323,937 | 11,531,687 |
| Хойшлогдсон даатгалын шимтгэлийн орлогын (бууралт) / өсөлт | | (108,744) | 97,449 |
| Дансны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт) | | (4,306,012) | 2,986,952 |
| Үйл ажиллагаанаас олсон мөнгө | | 4,710,975 | 2,588,594 |
| Төлсөн татвар | | (390,471) | (128,978) |
| Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | | 4,320,504 | 2,459,616 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалтанд зарцуулсан | | (242,143) | (1,186,853) |
| Биет бус хөрөнгийн худалдан авалтанд зарцуулсан | | (83,600) | - |
| Санхүүгийн хөрөнгө оруулалтаас хүлээн авсан / (олгосон) | | 4,130,382 | (4,790,642) |
| Түрээсийн сайжруулалтад зарцуулсан | | (401,682) | (1,071,298) |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн борлуулалтаас хүлээн авсан | | 310,000 | - |
| Үндсэн хөрөнгийн борлуулалтаас хүлээн авсан | | 267,319 | 206,382 |
| Хүлээн авсан хүү | | 5,647,917 | 4,632,137 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | | 9,628,193 | (2,210,274) |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| Түрээсийн төлөлт | | (707,548) | (617,291) |
| Ногдол ашгийн төлөлт | | - | (1,872,905) |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | | (707,548) | (2,490,196) |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт) | | 13,241,149 | (2,240,854) |
| Ханшийн зөрүүний нөлөө | 8 | (106,428) | (408,881) |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 12 | 1,037,665 | 3,687,400 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 12 | 14,172,386 | 1,037,665 |

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

* Аудитлагдсан санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 17-ийн дагуу толилуулагдсан ба зарим нэг дүнгийн ангилалыг сольсон ба залруулгууд хийгдсэн тул Компанийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлантай таарахгүй болно (Тодруулга 25).

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК